

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 03 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 03 дугаар сарын 27

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2020 оны 03 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 4 дүгээр хуралдаан 03 дугаар сарын 12-ны өдөр хуралдаж нийт 6 асуудал хэлэлцэж 4 тогтоол гарган, тэмдэглэлээр 2 үүрэг өгөв. Үүнд:

1. Хүүхэд хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн.

2. “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 91.0%-тай “Үр дүнтэй” гэж дүгнэн “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх 2020-2020 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөөг батлав.

3. “Ногоон хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, түүнтэй уялдуулан хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг тус тус баталсан.

4. Аймгийн “Байгалийн нөөцийн сан”-д гарсан өөрчлөлтийн тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 80 дугаар тогтоолоор батласан “Байгалийн нөөцийн санг бүртгэх, хүлээлгэн өгөх, тайланг хэлэлцэн дүгнэх журам”-ыг хэрэгжүүлж, орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн үр дүнгээр томилогдсон Засаг дарга нарт тухайн аймаг, сумын байгалийн нөөцийн санг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, энэ асуудлаар сумдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

5. Төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Төв аймгийн хөдөө аж ахуйн салбарын хөгжилд авъяас билэг, хүч хөдөлмөрөө дайчлан олон жил, үр бүтээлтэй ажиллаж үнэтэй хувь нэмэр оруулсан, мөн залуу хойч үеийг өөрийн арга туршлагаар залгамжлан хүмүүжүүлж байгаа 2 иргэнийг “Гавъяат агрономич цол”-оор, 5 иргэнийг “Алтан гадас одон”-оор, 15 иргэнийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

6. Төв аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны “Мэдэгдэл хүргүүлэх тухай” 39 дүгээр албан бичгийн тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ц.Ариунбаярын мэдээллийг хэлэлцээд Төв аймгийн Захиргааны хэргийн шүүхийн 2010 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 17-А дугаар шийдвэр, Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын Давж заалдах шатны шүүхийн 2011 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 47 дугаар магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн 2011 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 78 дугаар тогтоолыг биелүүлж, Лхүндэвийн Базаррагчаад шилжүүлэх 26971.7 мянган төгрөгийн 82 нэр төрлийн эд хөрөнгө аймгийн Засаг даргын Тамгын газрын балансад байгаа эсэх, чанар байдал нь ямар байгаа зэргийг нягтлан үзэж дүгнэлт гаргах Ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, түүнд Хурлын Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын хорооны Төлөөлөгч Ц.Буманбуянг оролцуулахыг аймгийн Засаг даргад зөвлөн хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

"Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төслөөс зарласан ИТХ-ын үйл ажиллагааг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийн шалгаруулалтад Алтанбулаг, Баянжаргалан, Баянчандмань сумын ИТХ-уудын санал шалгарсан байна.

Монголын Нутгийн удирдлагын холбооноос сонгуулийн бүрэн эрхийн хугацаа бүрээр "Шилдэг Төлөөлөгч" шалгаруулан, алдаршуулж байхаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчдөөс эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, орон нутаг болон сонгогдсон тойрогтоо идэвх санаачилгатай ажиллаж аймгийн ИТХ-ын төлөөлөгч Д.Батсуурь, Аргалант сумын ИТХ-ын төлөөлөгч Б.Халман нар "Шилдэг төлөөлөгч"-өөр шалгарлаа.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Аймгийн Засаг даргын зөвлөл 2 удаа хуралдаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээс гадна 7 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хорио цээрийн дэглэмийн үед төлөвлөгөөт сургалт, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Тайлант сард 4 агентлаг 135 албан хаагчид цахим сургалт хийж, цаг үеийн мэдээ мэдээ мэдээллийг шуурхай солилцлоо.

Аймгийн 2020 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор Аргалант, Архуст, Баяндэлгэр, Заамар, Мөнгөнморьт, Цээл сумдын багийн Явуулын төвийн тоног төхөөрөмжийг худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах захиалгыг техникийн нөхцөлийн хамт ОНӨГ-т хүргүүлсэн.

Шуурхай штабаас өгсөн чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сувилал, аялал жуулчлалын баазын судалгааг гарган танилцуулав. Аймгийн хэмжээнд нийт 27 сувилалын газар, 98 аялал жуулчлалын бааз /амралтын газар, хүүхдийн зуслан г.м/ бүртгэлтэй байна. Эдгээрээс одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй 4 сувилалд 280 сувилуулагч, 3 амралтын газарт 62 амрагч байна. Одоогоор амралт, сувилалын газарт гадаадын иргэн байхгүй байв.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, "Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ" 2020 оны урианы жилийн ажлын төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилт, батлагдсан төсвийн хүрээнд Батсүмбэр сумын Мандал 1 дүгээр баг, Баянчандмань сумын Замт 2 дугаар баг, Борнуур сумын Өгөөмөр 1 дүгээр баг, Заамар сумын Хайлааст 3 дугаар баг, Угтаалцайдам сумын Асгат 3 дугаар баг, Эрдэнэ сумын Тамган 5 дугаар баг, Эрдэнэсант сумын Улаанхудаг 5 дугаар багт тус бүр 1 хэсгийн ахлагчийг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулж байна.

Урианы жилийн ажлыг зохион байгуулах хорооны 3 дахь хурлыг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хийж, дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг сонсоход ихэнх ажил үйлчилгээ нь эхлэл төдий, удаашралтай байгаа тул ажил эрчимжүүлэх 5 үүрэг чиглэлийг өгч сум, байгууллагуудад хүргүүлээд байна.

Мөн 27 сумын урианы жилийн ажлын төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа. Хур систем нэвтрүүлэх боломж бүхий 8 багийн судалгаа гаргав.

Төв аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Архуст, Баян, Баянцагаан, Бүрэн, Өндөрширээт, Сэргэлэн суманд зөвлөн туслах ажлыг 2020 оны 03 дугаар сарын 18-20-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөн туслах ажлын хүрээнд сумын удирдлага зохион байгуулалт, урианы жилийн ажлын явц, Баг-97 төслийн хэрэгжилт, хүний нөөцийн чадамжийн чиглэлийн 17 үзүүлэлтээр сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын

дарга, Багийн Засаг дарга нар, Интернет мэдээллийн төвийн ажилтнуудад нэг бүрчлэн зөвлөгөө өгч, анхаарах асуудлыг сумдын удирдлагын бүрэлдэхүүнд танилцуулав.

2020 оны 03 дугаар сарын 27-ны байдлаар Монгол улсын төрийн одон медалиар шагнуулахаар дээд шатны байгууллагаас ирүүлсэн санал ирсэн 22 иргэний материалыг /Үүнээс ТАХ 12/ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэлээ.

Аймгийн хэмжээнд хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2019 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Ахлах түшмэлийн албан хаагчлын судалгааг гарган Удирдлагын академид хүргүүлж, цахим сургалтад хамруулж байна. Мөн шинээр томилогдсон төрийн албан хаагчдын судалгааг гарган ту академид хүргүүлээд байна.

Төрийн албаны стандартын хүрээнд: Төрийн албыг чадахжуулах чиглэлээр хэрэгжүүлж буй төслийн мэдээллийг ТАЗ-д хүргүүлээ.

Төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл мэдээллийг 3 байгууллагын хүсэлтээр гарган хүргүүлсэн. Хүний нөөцийн судалгааг аймгийн хэмжээнд шинэчлэн ажиллав.

Сургалтын мэдээлэл:

№	Сургалт зохион байгуулсан хугацаа	Сургалтад хамрагдсан	
		Байгууллага, албан тушаалтан	ТАХ-ийн тоо
1	2020.01.09	Сумдын ЕБС, Цэцэрлэгийн эрхлэгч нарын нэгдсэн сургалтанд Салбар зөвлөлөөс 2020 онд баритмлах чиглэл, хүний нөөцийн системийн бүртгэлийн тухай	54
2	2020.01.10	Сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, МЭҮТ-ийн мэргэжилтэн нарт зориулсан сургалт	41
3	2020.01.13	Мэдээлэл харилцаа, холбооны газартай цахим систем аймгийн хэмжээнд нэвтрүүлэхтэй холбогдон ERP системийн таинлцуулга сургалтанд хамрагдав	3
4	2020.01.22-23	Төрийн албаны Салбар зөвлөл, аймгийн ЗДТГ, МЕРИТ төсөлтэй хамтран “Багийн хамтын ажиллагаа хүчирхэг баг бүрдүүлэх нь” сэдэв сургалтыг сумын ЗДТГ-ын дарга, Бодлогын хэлтсийн болон зарим агентлагийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт зориулсан гэрчилгээ олгох сургалт	35
5	2019.01.29-30	Сумдын ИТХ. Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгдсэн сургалт Төрийн албаны Салбар зөвлөлөөс 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, анхаарах асуудлын талаар нэгдсэн чиглэл өгч ажиллав.	79
НИЙТ ДҮН		8 байгууллага, нэгж	212

Салбар зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2020.03.27-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	11
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	4
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	-
5	Төрийн албаны ерөнхий шалгалтын зар	9
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	1
НИЙТ ДҮН		25

2020 оны 03 дугаар сарын 27-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэр-лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Албан бичиг	31	5	4	1	-
2	Өргөдөл, гомдол	3	2	2	-	-

Гадаад харилцаа: Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд Япон улсын элчин сайдын яам, Төв аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд “Төв аймгийн Цээл сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн төсөл”-д гарын үсэг зурж, гэрээ байгууллаа.

БНСУ-ын Кёнгги аймгийн Пёнтаек хотын захиргаатай хамтран ажиллах санамж бичгийн төслийн албан ёсны орчуулгыг хүргүүлээд байна.

Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа олон улсын байгууллагын сайн дурын ажилтнуудын судалгаа гаргаж аймгийн шуурхай штабт хүргүүлсэн.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2020 оны 3 дугаар сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг **4784** иргэнд, өдөрт дунджаар 200-250 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв телевизүүд, аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд 3 дугаар сард аймгийн веб сайтад **61**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **132** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ.

Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **3-н** дугаарт 3 мэдээ мэдээлэл бэлтгэн өгч, олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар **18** мэдээ мэдээлэл гарсан нь давтагдсан тоогоор **54** удаа цацагдсан байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **2** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавихад 100%-тай байна. Хугацаа болоогүй 1 гомдол байна.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээлэл, Улсын онцгой комиссын уриалга, ЗӨСҮТөвийн Заавар батлах тухай А/15 дугаар тушаал, Ажил дээрээ гар угаах хэрэгтэйг анзаардаггүй 5 мөч, 1 удаагийн хамгаалах хувцас хэрэглэл өмсөх тайлах дарааллыг харуулсан зураг бичлэг, Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх зааварчилгаа, Шинэ коронавирусын халдварын сэжигтэй тохиолдлын хөнгөн хэлбэрийн гэрийн эмчилгээ сувилгаа ба тэдгээрийн хавьтлын менежмент мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

Шинэ коронавирусын халдвар дэгдэлтийн үед Төв аймагт тусгай чиг үүргээр ажиллах Ар жанчивлан рашаан сувилал, Ахмадын амралтын газрын сэжигтэй

тохиолдлыг тусгаарлах байруудад хийсэн дэмжлэгт хяналт шалгалтыг холбогдох асуултын хүрээнд хийж танилцуулгыг МХЕГ-т хүргүүлсэн.

Эрүүл ахуй, халдвар хамгаалал, авто тээврийн хяналт, хүнсний чанар стандарт, мал эмнэлэг, эм био бэлдмэл, эмчилгээний чанар, боловсрол, соёл, ургамал хамгааллын хяналтын чиглэлүүдээр давхардсан тоогоор 45 төрлийн зөвлөмж, 77 төрлийн сэрэмжлүүлгийг 698 иргэн, аж ахуйн байгууллагуудад хүргүүлэн ажилласан. 564 иргэн аж ахуйн нэгж байгууллага буюу 80.8%-д хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж байна.

Улсын Онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосонтой холбоотой Төв аймгийн нутаг дэвсгэрээр дамжин Улаанбаатар хот руу нэвтрэх Сэргэлэн сумын Өндөр дов, 4 дүгээр зөрлөгийн хяналтын постуудад хяналт тавьж ажилласан бөгөөд 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 06⁰⁰ цагаас 03 дугаар сарын 16-ны өдрийн 07⁰⁰ цагийн байдлаар нийт 45165 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн ба үүнээс гарсан 24728, орсон 20437 авто тээврийн хэрэгсэл, нийт 118677 зорчигч нэвтэрч үүнээс гарах чиглэлд 65638 зорчигч, орох чиглэлд 53039 зорчигч нэвтэрсэн. Энэ хугацаанд 81331 зорчигчоос эрүүл мэндийн хуудсаар асуумж судалгаа авч ажилласан.

Төлөвлөгөөт шалгалт: Байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр “Цэцүүх” трейд ХХК-д шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 10 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласан. Мөн 19-06-019/10 дугаартай Хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлж, ХАБ хариуцсан ажилтанд зөвлөгөө өгсөн.

Эрүүл ахуй, эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр хяналт шалгалт 5, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 5, тандалт судалгаа 2, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 1, шинжээчээр 1, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 11 цэцэрлэг, сургууль, хүнсний дэлгүүр хамрагдсан. Нийт акт 3, албан шаардлага 5, дүгнэлт 5-ыг гаргаж ажилласан.

Хүнс-Төлөвлөгөөт хяналт шалгалт 4 зөвлөн туслах үйлчилгээ 1, зөвлөмж 1, албан шаардлага 4-ийг гаргаж ажилласан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр Морьтхангай ХХК-ийн архины үйлдвэрт хөдөлмөрийн хяналтаар шалгалт хийсэн, Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудсаар 55 хувь буюу их эрсдэлтэй, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар 61 хувь буюу их эрсдэлтэй, хууль сахин мөрдөлтийн хувь 17,5 хангалтгүй хэрэгжсэн. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар хөдөлмөрийн харилцаа, аюулгүй ажиллагааг ханган ажиллах тухай зөвлөгөө мэдээлэл өгч, 11 заалттай албан шаардлага хүргүүлсэн.

Төлөвлөгөөт бус шалгалт: Байгаль орчны хяналтын чиглэлээр Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Эрдэнэ сумын нутаг аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй “Хариг трейд” ХХК-нд шалгалт хийж 150000 төгрөгийн шийтгэл оногдуулж, улсын /ахлах/ байцаагчийн 23 заалт бүхий хамтарсан албан шаардлагыг хүргүүлж ажилласан.

Хэрлэн голын сав газрын захиргаанаас ирүүлсэн гомдлын дагуу Хишигтэн нүүдэлчин ХХК-д шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулахаар улсын байцаагчийн 19-04-014/19 дугаартай 3 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Барилгын техникийн хяналтын чиглэлээр Төв аймгийн Сэргэлэн сумын 2 дугаар баг, Хоолтын даваанд байрлах “Юнител” ХХК-ний үүрэн холбооны станцын гадна цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэл, зураг төсөл, холбогдох бичиг баримтад шалгалт хийн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хугацаатай 19-07-020/21 дугаартай 2 заалттай албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулж ажилласан.

Хэмжил зүйн хяналтын чиглэлээр Төв аймгийн Зуунмод, Эрдэнэ, Баяндэлгэр, Аргалант, Алтанбулаг суманд үйл ажиллагаа явуулж байгаа мах боловсруулах үйлдвэрүүдэд шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Эрдэнэ хүнс ХХК, Түмэнт хурай ХХК, Эко фүүдс трейд ХХК-иудад улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласан.

Бага хүчин чадлын ус халаалтын зуухны техникийн аюулгүй ажиллагааг хангуулаагүйгээс сүүлийн жилүүдэд осол аваарь, гэмтэл, саатал гарч хүний амь нас эрсдэх, эрүүл мэндээрээ хохирох, барилга байгууламж, тоноглол, тоног төхөөрөмжид ноцтой эвдрэл, гэмтэл үүсэх зэргээр аюул, эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгож байгаатай холбогдуулан ус халаалтын зуухнуудын техник ашиглалт аюулгүй байдлыг хангуулах зорилгоор улсын ахлах байцаагчийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01-07-11/01 дугаартай зөвлөмжийг Аргалант-Илч ХХК, Төв Чандмань ДЭХГ ТӨХК, Винтер Гарден ХХК, Ану сервис ХХК, Өвбаян-Улаан ХХК, Эл Си Би ХХК-иудад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Ургамал хорио цээр, таримал ургамлын үр сортын хяналтын чиглэлээр 5 сумын 36 аж ахуй нэгжийн 42 дээжинд үр тариа, төмс, хүнсний ногооны тарих үрийн чанарын шинжилгээнд хамруулж улсын байцаагчийн дүгнэлт 2, акт 1 гаргасан.

Урьдчилан сэргийлэх шалгалт: Байгаль орчны хяналтын чиглэлээр Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай улсын байцаагчийн 19-04-014/11 дугаартай 6 заалт бүхий зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.

Дэд бүтцийн хяналтын чиглэлээр айл өрх, аж ахуйн нэгийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, “Эрчим хүчний тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, гэр хороолол болон орон сууцны айл өрхийн оруулгын кабель, монтаж холболтын байдалд үзлэг хийж, галын аюулгүй байдлыг хангах аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар нийт **788** айл өрхийн **1458** иргэнийг хамруулж цахилгаан шугам сүлжээний ашиглалтын аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх тухай улсын байцаагчийн заавар зөвлөмж өгч, **212**-н зөрчил дутагдлыг илрүүлэн, **65** зөрчлийг газар дээр нь арилгуулж бусад зөрчилд арилгуулах талаар заавар зөвлөмж өгч ажилласан.

Хүнсний чанарын хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалтыг 5 сумын 32 худалдааны газар, 33 хоолны газар, 4 хүнсний цех нийт 69 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хийж хадгалалтын хугацаа хэтэрсэн 35 нэр төрлийн 20.345 кг, 146 ширхэг, 621300 төгрөгний хүнсний бүтээгдэхүүн хураан авч устгуулахаар Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн. Эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлээгүй 3 зоогийн газрын үйл ажиллагааг /005784, 005793, 005783 лац/ зогсоон илэрсэн зөрчлийг арилгуулахаар 27 заалттай 3 албан шаардлага хүргүүлэн ажилласан.

Баталгаажуулах хяналтын чиглэлээр: Харилцаа холбооны хяналтын чиглэлээр Мобиком корпораци ХХК-н хүсэлтээр Төв аймгийн Батсүмбэр суманд шинээр баригдсан үүрэн холбооны дамжуулах бааз станц, антенн цамхагт ногоон гэрчилгээ олгосон.

Байгаль орчны хяналтын чиглэлээр Химийн хорт болон аюултай бодисын агуулах, ажлын байранд үйл ажиллагаа явуулахаас өмнө баталгаажуулах хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Баяндэлгэр сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Чулуут интэрнэйшнл” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу химийн бодисын агуулахын байранд баталгаажуулах хяналт шалгалтыг хийж улсын байцаагийн дүгнэлт гаргаж ажилласан.

Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр Үйлдвэрлэлийн ослын актыг хянан баталгаажуулах хяналтыг Монхорус электрик ХХК, Тера экспресс ХХК-д хийж 4 ажилтны үйлдвэрлэлийн ослын актыг баталсан.

Нью семетри ХХК-ийн хүсэлтийн дагуу Baltur хаягдал шатаах зуухны аюулгүй ажиллагаатай холбоотой бичиг баримтыг хянан үзэж тоног төхөөрөмжийн гэрчилгээ олгосон.

Итгэмжлэгдсэн лаборатори нь тайлант хугацаанд хяналт шалгалт, ААН иргэний хүсэлтийн хүрээнд 219 сорьцыг шалгаж хүлээн авч 395 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон байна. Үүнээс 33 сорьц 33 үзүүлэлтээр үрийн чанарын болон хорио цээрийн шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангаагүй.

Онцгой байдлын газрын хүрээнд: Коронавирусээс урьдчилан сэргийлэх Аймгийн шуурхай штабын албан хаагчид сумдаас ирсэн мэдээ мэдээллийг нэгтгэн аймгийн онцгой комисс, УОКомисст шуурхай хүргэж гарсан тушаал шийдвэрийг цаг алдалгүй шуурхай зохион байгуулан ажиллаж байна.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 35 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 207-н зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 91 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгсөн.

Хяналт шалгалтанд хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 10-н аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож ажиллаа.

Объектын гал түймэр 6 удаа гарсан байна. Үүнд: Сэргэлэн, Мөнгөнморьт, Цээл, Борнуур, Зуунмод, Эрдэнэсант гэсэн сумдад гарч 186,162,000 тгргийн хохирол учирсан байна.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран “Зууны мэдээ” сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 03 сарын дугаарыг “Малчин хувиараа хөдөлмөр эрхлэчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хуулийн сэдвээр бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 63 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 109 иргэн болон сум, байгууллагад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 24 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 5 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, 4 шүүх хуралдаанд оролцож ажилласан.

“Манзушир” ХХК-ний хувьчлалын асуудлыг судалж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, ажлын хэсэг байгуулан ажиллахаар шийдвэрлэв.

Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлын судалгааг хууль хяналтын байгууллага, 27 сумаас гаргуулан авч, хохирлыг төлүүлэх санал боловсрууллаа.

“Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх 2016-2019 оны хөтөлбөр”-ийн тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж 91.0 хувьтай дүгнүүлэн, “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан

сэргийлэх 2020-2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г батлуулж, сум, байгууллагад хүргүүлсэн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн анхдугаар хурлыг зохион байгуулж, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлууллаа.

Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/124, А/130 тоот захирамж, Улсын онцгой комиссын 09 дүгээр хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу шашны байгууллагуудад 72 удаагийн хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй. Тус ажиллагаанд 622 албан хаагч үүрэг гүйцэтгэв. Аймгийн хэмжээнд 61 шашны байгууллага байгаагаас зөвшөөрөлтэй 18, зөвшөөрөлгүй 42, буддын шашны 27 хийд, Исламын шашны 1, Христийн шашны 33 сүм, цуглаан, чуулган, эсийн бүлэг бүртгэгдсэн.

Архуст, Баян, Баянцагаан, Бүрэн, Өндөрширээт, Сэргэлэн 6 сумдад хууль зүйн салбарын хүрээнд 7 чиглэлээр буюу Архив, албан хэрэг хөтлөлт, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сумдын зөвлөл болон Хүний эрхийг хангах салбар хороодын үйл ажиллагаа, эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын явцад зөвлөн тусалж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Архивын үйлчилгээ: Төрийн архивын эх баримтаас 195 иргэний хүсэлтээр 639 хуулбар хувь, 128 лавлагаа, 239 хөмрөгийн 858 хадгаламжийн нэгж ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилж, 2.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

3 хөмрөгийн 61 хадгаламжийн нэгжийн 6230 хуудас баримтын 24736 хүний нэр, 5428 заалтын тоо, 5428 тушаалын мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж, 2 хөмрөгийн 70 хадгаламжийн нэгжийн 5428 заалтын 6232 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэж, 2 хөмрөгийн 392 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: Эд хөрөнгийн бүртгэл: Цахим санд нийт 54671 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9955, Газар өмчлөх эрхийн 44716 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 16035.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт төгрөгийг 42.7 сая, үл хөдлөх худалдан борлуулсны 26.0 сая, тэмдэгтийн хураамжаас 1.4 сая төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: Тайлант хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 58 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 37 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Тэмдэгтийн хураамжийн орлого 1.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл: Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 244 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47 хэргээр буюу 23.8 хувиар өссөн, хөнгөн гэмт хэрэг 206 бүртгэгдсэн нь 47 нэгжээр буюу 22.8 хувиар, хэрэг бүртгэлтийн гэмт хэрэг 232 бүртгэгдэж 80 нэгжээр буюу 34.4 хувиар, мөрдөн байцаалтын гэмт хэрэг 82 бүртгэгдэж 37 нэгжээр буюу 77.7 хувиар тус тус өссөн, хүнд гэмт хэрэг 38 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхтэй ижил түвшинд байна. Гэмт хэргийн илрүүлэлт 34.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 хувиар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа: Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй

унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн 18 шүүхээр баривчлагдсан 47, албадан саатуулагдсан 6, ар гэрт нь хүлээлгэн өгсөн 5, нийт 76 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авсан.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу Төв аймгийн нутагт 34 пост гаргаж 43 алба хаагч, бусад байгууллагын 133 алба хаагч нартай 8 хоног 24 цагаар үүрэг гүйцэтгэж гачигдал гарсан 1965, албан ажилтай 2357, эмнэлгийн байгууллагад зайлшгүй үзүүлэх шаардлагатай 1911 иргэнийг нэвтрүүлж, хяналт тавьж ажилласан.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 35 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, 14.7.5-д заасан зөрчлөөр 8 иргэнийг сум дундын шүүхээр баривчлуулж, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 2918 жолоочийг 87.8 сая төгрөгөөр торгосон.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Криминалистикийн шинжилгээ-40, Магадлан шинжилгээ-38, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-196, гарын мөрийн санг баяжуулсан-117, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 162 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
3-р сар	321	131	14	438	113	325	25.8%
	4335531.9	863179.9	533217.6	4665494.2	457488.9	4208005.3	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

Хөрөнгө оруулалт, барилга хот байгуулалтын үйлчилгээ: Аймгийн ТЕЗахирагчид эрх шилжүүлж хэрэгжүүлэхээр Япон Улсын “Өвсний үндэс хөтөлбөр”, Монгол Улсын БСШУСЯам, ЗТХЯам, ЭМЯамнаас нийт 26,090.1 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээ шилжин холбогдох захиалагч байгууллагаар аймгийн ГХБХБГазар, аймгийн БЗОСК ОНӨААТҮГазрыг тус тус томилсон.

Тайлант оны эхнээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 36,731.7 сая төгрөгийн 82 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас 36 төсөл, арга хэмжээний тендерийг зарлаж хэрэгжилт 43 хувьтай байна.

ХАА-н чиглэлээр: Газар тариалангийн хүрээнд: Хаврын тариалалтын аймгийн штабыг Засаг даргын 2020 оны А/146 тоот захирамжаар байгуулан, ажлын төлөвлөгөө боловсрууллаа. 2020 онд 116365 га талбайд тариалалтаар хийгдэхээр төлөвлөгдсөн. Үүнд:

- Үр тариа 95449 га, үүнээс улаанбуудай 83355 га,
- Төмс 7816 га,
- хүнсний ногоо 1600 га,
- Таримал тэжээлийн ургамал 11500 га

Аймгийн хэмжээнд хаврын тариалалтад шаардлагатай 1457.5 мян.тн литр шатахуун, 6082 тн-улаан буудайн үр, 1746 тн-таримал тэжээлийн ургамлын үр саналыг ХХААХҮЯ-нд хүргүүлэн ажиллалаа.

Хяаабуи дааеаеаеаеаа шаардлагатай тоног төхөөрөмж, ажиллах хүчний судалгаа шинэчлэн гаргалаа. Үүнд:

- 50-700 морины хүчин чадалтай 936, 1160, үүнээс үр тарианы хийн үрлэгч 32, 416 бүхий техник
- Үрийн будааны үйлчилгээнд нийт 2375 тээврийн хэрэгсэл
- 422, 32, механик 41, агрономич 46, 2694, 339 нийт 33574 хүч

Баянчандмань, Борнуур, Баянцогт, Цээл сумдад хаврын тариалалтын техник засварын ажил эхлүүлээ.

Аймгийн 10-н сумын зооринд төмс - 18361 тн, шар лууван - 783 тн, шар манжин-419 тн, сонгино-1 тн, байцаа - 215.1 тн, бусад ногоо - 50 тн нийт 19829.1 тонн төмс, хүнсний ногоо хадгалдаж хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж байна.

Мал аж ахуйн хүрээнд: Мал аж ахуйн хаваржилт, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх, төл хүлээн авах бэлтгэлийг үе шаттай зохион байгуулж байна.

Аймгийн хэмжээнд 12056 малчин өрхөд 4900,0 мян /толгой мал хаваржиж, үүнээс 2300,0 мян/толгой хээлтэгч мал төллөхөөс 88456 толгой мал төллөж, 88984 толгой төл гарсанаас 88050 толгой төл бойжиж байна. Гарсан төлийн 1028 толгой төл мал хорогдсон нь нийт бойжиж буй төлийн 1.1 хувийг эзэлж байна. Оны эхний нийт малын 0.07 хувь буюу 3556 том мал зүй бусаар хорогдсон байна.

Мал аж ахуйн хаваржилт, төл хүлээн авахад 27-н сумын малчид, мал бүхий иргэдэд “Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц”-өөс 320 тн өвс, 80 тн тэжээл хямдралтай, хөнгөлөлттэй нөхцөлөөр хуваарилан, “Улаанбаатар” гурил тэжээлийн үйлдвэрээс 100 тн тэжээл татах ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд нийт нутгийн 80 орчим хувьд үлийн цагаан оготно тархан, бэлчээрийн талбайд нь үлийн цагаан оготны хэт олшрол болж, бэлчээрийн ургамлын 40-60 хувь нь хөнөөгдсөн. Бэлчээрийн хөнөөлт мэрэгчтэй тэмцэх ажлыг тал хээрийн 14 сумын 100.0 мян/га талбайд технологит хугацаанд үр дүнтэй гүйцэтгэхэд ОНТ-ийн 100,0 сая төгрөгийн санхүүжилт эрх шилжүүлэн, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, сумдын ЗДТГ-т зөвлөмж чиглэл хүргүүлээ.

Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: Хорио цээрийн дэглэм тогтоож хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ, хангалт, нөөцийн судалгааг 7 хоног тутам гарган аймгийн онцгой комисс, ХХААХҮЯамны шуурхай штабт хүргүүлэн, 15-30 хоногийн хүнсний нөөц бүрдүүлэлт хийж ажиллалаа.

Хүн амын гол нэрийн бүтээгдэхүүн мах, махан бүтээгдэхүүний хүртээмж, хангамжийг нэмэгдүүлэх, махны үнийн хөөрөгдлийг тогтворжуулах, бууруулах бодлогыг хэрэгжүүлэн Эрдэнэ хүнс ХХК мах боловсруулах үйлдвэр, Зуунмод мах боловсруулах ОНӨУҮГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ хүрээнд Эрдэнэ хүнс ХХК нь хонины мах -3 тн, ямааны мах-2 тн, нийт 5 тн махыг тус бүр 3 кг-ар савлан, Зуунмод мах боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгч, Зуунмод сумын 6-н багийн 7 цэгээр 03-р сарын 16-ны өдрөөс эхлэн 1 кг хонины мах 7000 төгрөг, ямааны мах 6000 төгрөгөөр борлуулж байна.

Давсны мэдээлэл сурталчилгааны дэлхийн 7 хоног өдрөөр “Давсны хэрэглээг бууруулцаа” уриан дор цуврал 8 зөвлөмж, мэдээллийг аймгийн ХХААГ-ын цахим хуудсаар олон нийтэд сурталчилж, 27 сумын 228 худалдаа үйлчилгээний цэгт танилцуулга, брошур байршууллаа.

Мал эмнэлгийн үйлчилгээ: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1803.6 мян/мал хамруулахаар Биокомбинат УТҮГ-тай вакцин бэлтгэн нийлүүлэх гэрээ байгууллаа. Мал эмнэлгийн үйлчилгээний 89 нэгжтэй гэрээ байгуулан 68.6 хувьтай байна.

- Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 158.8 литр буюу 57.7%
- Цусан халдвартаас сэргийлэх вакцин 1580 литр буюу 63.8%
- Шөвөг яраас урьдчилан сэргийлэх вакцин 167.8 тун буюу 83.9%
- ДХХ вакцин 1600 литр буюу 57.9%
- Сахуугаас урьдчилан сэргийлэх вакцин 320 литр буюу 80%

Шүлхий өвчнөөс урьдчилсан сэргийлэх вакцинжуулалтыг Борнуур, Аргалант, Батсүмбэр, Баянчандмань Баянцогт, сумдад 03 дугаар сарын 04-ний өдрөөс эхлүүлэн 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шинэ Кароновирус цар тахлаас урьдчилан сэргийлж голомтын цэгийн 152 м2, устгалын цэгийн 289 м2, нийтийн эзэмшлийн 6 зам талбайн 720 м2, автозогсоолын 120 м2, орон сууцны 640 м2, гэр хорооллын айл өрхийн муу усны нүх, жорлон 420 м2 нийт 8.1 мян/м2 талбайд халдваргүйжүүлээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хяналтын цэгээр малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлийн хяналтыг 24 цагаар хийлээ. Хяналтын цэгээр мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэж буй 456 тээврийн хэрэгсэл, 1216 толгой амьд мал, 1203,0 тн мах, махан бүтээгдэхүүн, 76566 ширхэг арьс шир, 170 тн ноолуур, 12.7 тн айраг зэрэг бүтээгдэхүүнд эрүүл ахуй, гарал үүсэл, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийлээ.

Газрын харилцааны үйлчилгээ: ГЗБГЗЗГ- т “Хот байгуулалтын мэдээллийн сан”-ийн дэд санг үүсгэж байгаатай холбогдуулан инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл ажлын мэдээлэл, судалгааг гарган хүргүүлсэн.

Мөнгөнморьт, Архуст, Баянцагаан, Сэргэлэн, Өндөрширээт сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд захиалагчаар ажиллаж байна. Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр Архуст суманд “Эрхэт констракшн” ХХК, Мөнгөнморьт суманд “Эм Эм архитектур” ХХК, Баянцагаан, Өндөрширээт сумдад “Инженер геодези” ХХК, Сэргэлэн суманд Өрх” ХХК-иуд шалгаран гэрээ байгуулан гүйцэтгэж байна.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хүрээнд 2 барилга байгууламжид комисс ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авлаа.

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар олгохоор тусгагдсан Алтанбулаг-26, Баянхангай-3, Жаргалант-20, Сэргэлэн-38, Цээл-9, нийт 96 дуудлага худалдааг www.mle.mn газрын цахим биржийн сайтад бүртгэж баталгаажуулсан.

Газрын төлбөрийн орлого 2900 сая төгрөг төвлөрүүлэхээс 3 сарын 24-ний байдлаар 380.33 сая төгрөг төвлөрүүлсэн. Үүнээс газрын дутуу төлөлтөөс 177.3 сая төгрөг, газрын дуудлага худалдааны анхны үнээс 50.2 сая төгрөг төвлөрүүлэв. Газрын төлбөрийн цахим системд 14325 эзэмшигч, ашиглагчдад газрын төлбөрийн ногдуулалт үүсгэн, нэхэмжлэлийг баталгаажуулаад байна.

Egazar.gov.mn/cadastre сайтад нэвтэрч иргэн, хуулийн этгээд газрын кадастрын мэдээллийн сангаас өөрийн өмчлөл, эзэмшлийн газрын мэдээллийг харах, танилцах, 2020 оны сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй танилцах боломжийг бүрдүүлээ.

Газар тариалангийн 10 суманд атаршсан газарт ус, салхины элэгдэл, эвдрэлд орсон газрын судалгааг авч ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Байгаль орчны чиглэлээр: Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 17 дугаар тушаалын дагуу хүчин төгөлдөр байгаа хайгуул, ашиглалтын болон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, сунгалт, цуцлалтын үйл ажиллагааны баримт бичгийн бүрдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгах ажлыг 2020 оны 03 дугаар сарын 01- 25-ны хугацаанд хийж гүйцэтгэв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэлэлцүүлэн батлуулав.

Хөндөгдсөн эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэн, эзэнгүй орхигдсон талбайгаас 10 га-д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлын даалгавар; Бэлчээрийн олон наст тариалах ажлын даалгавар, техникийн тодорхойлолт; Зуунмод гол дагуу мод тарих, Эрдэнэ сумын ойн санд тархсан хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх, Зуунмод, Алтанбулаг, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл, Баянжаргалан сумдад мод тарих ажлын даалгаврыг боловсруулж ОНӨГ-т хүргүүлсэн.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: 27 сумын 221 байгууллагын мэдээ тайланг нэгтгэж ТӨБЗГазарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

3 сум, 5 төсөвт байгууллагаас хөрөнгө шийдвэрлүүлэхээр ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, материалын бүрдлийг хангуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангаж байна.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 12 өрх, нийт 24 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулж, түрээсийн 27,000,000 төгрөгийг төлбөрийг төсөвт төвлөрүүлээд байна.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулах хүсэлт ирүүлсэн 9 бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулж Баталгаажуулалтын зөвлөлийн 03 дугаар хуралдаанаар 9 үйлчилгээ бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаагаар олголоо.

Зуунмод сумын худалдаа үйлчилгээ, мөнгөн тооцоонд ашиглаж байгаа нийт 29 ш массын хэмжих хэрэгсэл, Зуунмод, Лүн сумын ШТС-ын хэмжих хэрэгслүүдэд улсын ээлжит баталгаажуулалт хийв.

УБЦТС ХХК Зуунмод салбартай хамтран ажиллах гэрээний дагуу 1 фазын 127 айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын цахилгаан тоолуурыг шалгаж баталгаажууллаа.

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандартын талаарх мэдээлэл сургалтыг Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгүүдэд тус тус зохион байгуулсан.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Ерөнхий боловсролын 29 сургуулийн захирал, 34 цэцэрлэгийн эрхлэгчийн 2019-2020 оны хичээлийн жилийн 3 дугаар улирлын ажлын үр дүнгийн тайлан, хэрэгжилтийн үнэлгээний дагуу улирлын урамшуулал олголоо.

2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр сумдын 12 жилийн сургалттай 20 сургуулийн захирал сургалтын менежер, 12 дугаар ангийн багш нартай цахим хурал хийж ЭЕШ-д бэлтгэх, шинэ короно вирусын халдвараас сэргийлэх, ариутгал халдваргүйтэл хийх, цаг үеийн ажлын явц үр дүнтэй танилцав.

Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 16 өдөр баталсан “Зарим сумдад зөвлөн туслах ажлын хэсгийн удирдамж”-ын дагуу Архуст, Баян,

Баянцагаан, Сэргэлэн, Өндөрширээт, Бүрэн сумдад ажиллан боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны явц, хорио цээрийн дэглэмийн үеийн удирдлага зохион байгуулалт, салбарын хүрээнд хэрэгжиж буй бодлого хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт хийж, цахим хичээлийн явцтай танилцан, сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч, багш, ажилтан албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах салбар хороог хуралдуулж 2019 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүнг танилцуулан 2020 оны төлөвлөгөөг батлууллаа.

Хүүхдийн хөгжил хамгаалал үндэсний хөтөлбөрийг 2020-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

“Цахим эмч” шууд нэвтрүүлгийг эхлүүлж, 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн шинэ дугаараар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сүрьеэгийн тасгийн зөвлөх их эмч О.Оюунтүлхүүртэй хамтран “Сүрьеэ өвчний талаар болон оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх” талаар иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Төв телевизтэй хамтран “Төв түмний төгөлдөр бүсгүйчүүд” шууд нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: Шинэ короно вирусын халдвараас сэргийлэх, халдваргүйжүүлэх бодис, багаж хэрэгсэл материал худалдан авах зардлын тооцоог ЕБС, цэцэрлэг тус бүрээр гаргаж ЕБС-иудад нийт 70.1 сая, цэцэрлэгүүдэд 31.5 сая төгрөгийн хуваарь хийж хүргүүлээ.

Аймгийн боловсрол, соёлын салбарын ажилтан, албан хаагчид сайн дурын хандивын аян өрнүүлж нийт 56.5 сая төгрөгийг аймгийн Онцгой комисст хандивлав.

2020 оны 3 сарын 30-ныг хүртэл хөл хорио сунгасан учир 3 дугаар сарын эхний 7 хоногт 2 сарын цахим хичээлүүдийг давтан гаргасан. Одоогийн байдлаар "Цахим хичээл - Төв аймаг" сайтад сургууль цэцэрлэгийн багш, удирдах ажилтны 96,7%, сурагчдын 62,5% нь нэгдээд байна.

Монгол туургатан театрын үйлчилгээ: “Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ” урианы жилийн хүрээнд орон нутгийн иргэдэд соёл урлагийн үйлчилгээг хүргэхээр Төв телевизтэй хамтран уран бүтээлчдийнхээ тоглолтыг цахимаар 4 цуврал болгон хүргэлээ.

Музейн үйлчилгээ: ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнтэй хамтарч “Төв аймгийн өв соёлын дээжис” номонд музейн шилдэг үзмэрийн талаарх мэдээллийг оруулахаар хамтарч ажиллаж, Редакцийн зөвлөлд хүргүүлээд байна.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: 2020 оны 2-р сард 24-н байнгын уншигч, 28 ирэгсэд, нийт 52 уншигчдад 62 ном олгож уншуулсан. Шинэ номын “Монголын хатад” үзэсгэлэн зохион байгуулсан. 3-р сарын байдлаар нийт 1.707500 төгрөгийн ном, хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулан бүртгэлд авч, электрон каталогит оруулан уншигчийн хүртээл болгож байна.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг 1 сарын хугацаатай 60 номоор Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгал, Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад хүргэв.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Аймгийн ЕБС-ийн сурагчдын дунд цахим уралдааныг “Миний дуртай спорт” сэдэвт гар зургийн уралдаан, “Шатрын бодлого бодох”, Хөл бөмбөгийн “Хэн сайн жонглёрдох вэ” тэмцээн, Гар дээр суниалтын тэмцээн, Таеквондогийн дасгалыг хэн сайн хийх вэ, шагайн харваа, бага, дунд, ахлах ангийн сурагчдын гэртээ хийх гимнастикийн дасгалын тэмцээнүүдийг зарлан явуулж байна.

ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-аас буцалтгүй тусламжаар 12 сая төгрөгийн үнэ бүхий жюү-догийн татамыг олголоо. Мөн Дэлгэрхаан сумын ЕБС-д 32 ширхэг дэвжээ олгов.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10–ны өдөр **хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэрийг гарсаны дагуу** Улаанбаатар хотоос хөл хорионд орсон бага насны 4 хүүхэдтэй эмэгтэйг гэртээ ирэх хүртэлх хугацаанд 4 хүүхдийг учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажилласан.

“Хамтдаа хөгжье” цахим сарын аян зохион байгуулж 12 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж, хүүхэд багачуудын хөгжлийг дэмжих, эцэг эхчүүдийн үр хүүхэддээ зориулах цагийг нэмэгдүүлэх, хамтдаа бүтээж хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх зорилготой ажлыг олон нийтэд мэдээлэн ажиллаж байна. Ахлах ангийн сурагчид, МСҮТ-ийн оюутануудад Гитар тоглож сурах цуврал хичээлийг фэйсбүүк, youtube сайтаар дамжуулан түгээсэн.

Аяны хүрээнд “Үлгэрч гэр бүл”, “Гэрийн дүрэм”-ээ тогтоон дагаж мөрдөх 2 төрлийн цахим уралдааныг зарлан шалгаруулалт хийсэн. 8 удаагийн видео хичээлээр хөгжимтэй дасгал, цаасан урлал, хүнсний бүтээгдэхүүн хийх аргачлал, 4 төрлийн ахуйн осол, болзошгүй аюул эрсдлээс сэргийлэх зөвлөмж, коронавирусууд сэргийлэх 5 төрлийн постеруудыг бэлтгэн цахимаар түгээлээ.

Үндэсний хэмжээнд зохион байгуулж буй “Залуучууд коронавирусуудын эсрэг нэгдэж байна” цахим аяныг Төв аймагт зохион байгуулж урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 төрлийн видео шторк, 4 төрлийн зурагт хуудсыг 400 ширхэг хэвлэн олон нийтийн газар, гудамж талбай, цахим сүлжээнд байршуулсан.

Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн хэрэгцээг тодорхойлох хүүхэд хамгааллын түргэвчилсэн үнэлгээгээр 15 сумын 45 өрхийн 189 хүүхэд хүнс, эрүүл ахуйн бараа бүтээгдэхүүнийг 1.152.000 төгрөгөөр авч сумдад түгээлээ.

МУЗГ-аас зохион байгуулсан “Хүүхэд эрхэм хэрэглэгч” аяны “Миний гэр-аюулгүй орчин” арга хэмжээний хүрээнд “ТБС” телевиз болон Монголын үндэсний телевизээр эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэл хүргэн 6 бүлгийн 39 асуулга бүхий үнэлгээний хуудсаар 21 сумын 73 байгууллагын 940 албан хаагч хамрагдаж, 4945 эрсдэл илрүүлж, 3015 эрсдлийг засч сайжруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2020 оны 3-р сарын байдлаар 1750 иргэнд 976.1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1098 иргэнд 298.1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 918 иргэнд 174.7 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 430 ахмад настанд 51.8 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 5150 ахмад настанд 417.9 сая төгрөгийн насны хишиг, 172 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 15.4 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 3591 иргэнд 119.0 сая төгрөг, жирэмсэн 831 эхэд 83.2 сая төгрөгийн тэтгэмж, алдар цолтой 59 ахмад настанд 28.7 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4511 эхэд 671.1 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 284 эх /эцэг/-т 117.0 сая төгрөг, 2 ихэр хүүхэд төрүүлсэн 6 эхэд 12.0 сая төгрөг, алдарт эхийн 1, 2-р одонтой 8376 эхэд 939.7 сая төгрөгийг тус тус олгосон.

Шинэ төрсөн 186 хүүхдийн мэдээллийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. ӨМНСанд бүртгэлтэй 18508 өрхийн 32631 хүүхэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж 1957800.0 төгрөгийг зарцуулсан.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 34 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 17 ажил олгогч байгууллага, иргэн, 26 сул чөлөөтэй ажлын байр, 18-н ажилд зуучлагдсан иргэн, 22 шинэ ажлын байрны мэдээллийн санд орууллаа. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах 18 иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан 15 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн банкаар дамжуулан олгох жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 2017-2019 онд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч 3 иргэнд түрээсийн төлбөрийн хөнгөлөлт олгох гэрээг байгуулж, 4 сараас олгохоор шийдвэрлэлээ.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 2 удаа хуралдаж, нийт 207 иргэний асуудал хэлэлцсэнээс шинээр 24 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 174 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 9 иргэнийг цуцалсан.

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 484 дүгээр тогтоолоор баталсан “Зарим иргэний тэтгэврийг нэмэгдүүлэхэд баримтлах журам”-ын дагуу нийт 174 тэтгэвэр авагчдад 74 300 000 төгрөгийн нэмэгдлийг олгоод байна.

Аймгийн хэмжээнд 14247 тэтгэвэр авагчдад 5.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон. Архивын лавлагаа 380, тодорхойлолт 232 гарган иргэд даатгуулагчдад үйлчилсэн.

65 хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 8.6 сая, жирэмсэн амаржсаны тэтгэмж 72 даатгуулагч 93 сая, ажилгүйдлийн тэтгэмж 54 даатгуулагчид 81.8 сая төгрөг, нийт 183.4 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр ЭМГ, ОБГ, МХГ хамтран 26 сумын Эрүүл мэндийн төв, сумдын шуурхай штабын өндөржүүлсэн бэлэн байдлын үйл ажиллагаатай танилцан, нөхцөл байдлын үнэлгээ хийж, эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодис, хамгаалах хэрэгслийн нөөцийн судалгаа гарган, зөвлөн туслав. ЭМЯ-аас хуваарилсан 11.7 сая төгрөгийн хувийн хамгаалах хэрэгслийг сумдын Эрүүл мэндийн төвд хүлээлгэн өглөө.

“Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 олон улсын стандарт нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд World Standart Consulting ХХК-тай гэрээ байгуулан зөрүүгийн шинжилгээ хийлгэсэн.

2020 онд нийт 32 багцын эм, эмнэлгийн хэрэгслийн тендер зарласнаас 21 багцад нийт 14 компани шалгарч 12 компани эм, эмнэлгийн хэрэгслийг захиалгын дагуу авч 26 сумын Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт нийлүүллээ.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 21.3 сая төгрөг шийдүүлж, 12 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 8 нэр төрлийн ариутгал, халдваргүйтгэлийн бодис авч тусгаарлан ажиглах 2 байранд ашиглах нөөц бүрдүүллээ. ЭМЯ-аас 12.5 сая төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг вакцины хөргөгч нийлүүлэгдсэн. АНЭ-ийн төрөх тасаг, Бүрэн, Сүмбэр сумдад хуваарилсан.

Угтаалцайдам, Жаргалант, Лүн, Зуунмод, АНЭ-т бүртгэгдсэн амьгүй төрөлт, нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахад 30 эмч, эмнэлгийн ажилтан оролцсон.

ЭМГ-ын дэргэдэх Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл хуралдаж коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж

үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор сумын эмийн эргэлтийн сангаас 2.0 сая төгрөг зарцуулах эрхийг сум бүрт олгохоор шийдвэрлэсэн.

Дархлаажуулалтын 9 нэр төрлийн 40,058,084,00 үнэ бүхий вакцин биобэлдмэл, эм эмнэлгийн хэрэгслийг татан авч анхан шатны 25 эрүүл мэндийн байгууллагуудад тараан олгосон.

ЭМГ-ЗХӨТСТ- Хүнсний дэлгүүр 12, Скай, Андууд худалдааны төв, Шатхуун түгээх газар 9, төрийн үйлчилгээний 5 байгууллагын нийт 39022 мкв талбайд халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн. Аймгийн Онцгой байдлын газартай хамтран Зуунмод сумын ЕБС, СӨБ-н гадна тоглоомын талбай болон нийтийн эзэмшлийн 16000 мкв талбайд хөрсний халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн.

Алтанбулаг суманд Францын иргэнтэй хамт онгоцоор ирсэн 1 хүн, хавьтал болсон 6 хүний тархвар судалгааг хийж, мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан сорьцийг ХӨСҮТ-д хүргүүлсэн, хариу сөрөг гарсан. Хустайн байгалийн цогцолбор газрын ажилтан болон тэдний ар гэрийн 61, айл өрхийн 27, амарч аяласан 34 буюу нийт 122 иргэнийг тогтоон тархвар судалгааг хийсэн.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах Эрүүл мэндийн алба нь 24 цагаар хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж өдөр бүр эрүүл мэндийн байгууллагуудаас мэдээг нэгтгэн 06.00-08.00 цагт Эрүүл мэндийн хөгжлийн төвд, 17:30-19:00 цагийн хооронд Онцгой байдлын газарт хүргүүлэн, МХГ, ЦГ, ОБГ, ТГ-тай холбоотой ажиллаж байна.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлого: Орлогын төлөвлөгөө 2 дугаар сарын байдлаар орон нутаг 644,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 686,1 сая төгрөг төвлөрүүлж 106,4 хувьтай, 6,4 хувиар давуулан биелүүлсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 2401,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 2796,4 сая төгрөг төвлөрүүлж 116,4 хувьтай, 394,6 сая төгрөгөөр буюу 16,4 хувиар тасарсан байна. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 355,6 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 119,2 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баяхангай, Баянцагаан, Баянцогт, Бүрэн, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал зэрэг 13 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Батсүмбэр, Баянжаргалан, Баянчандмань, Борнуур, Дэлгэрхаан, Жаргалант, Заамар, Сэргэлэн, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 13 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян сум байна.

Төсвийн зарлага санхүүжилт: Сумдад эхний 02 сарын байдлаар нийт 13535.8 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл: Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 6679,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 4493,9 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 2185.1 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 1513.3 сая төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 1436.3 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 77.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 104,8 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 136.9 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 5101.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 3498.6 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 1603.2 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлага: 2020 оны 2-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 56167.1 мянган төгрөгийн авлага, 182454.3 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 99010.8 мянган төгрөг буюу 54.2 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 10430.3 мянган төгрөг буюу 5.7 хувь нь цалингийн өглөг, 12586.1 мянган төгрөг буюу 6.9 хувь нь НДШимтгэлийн өр, 10020.4 мянган төгрөг буюу 5.4 хувь нь гэрэл цахилгааны зардлын өгрлөг, 26257.0 мянган төгрөг буюу 14.4 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 24149,7 мянган төгрөг буюу 13.2 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Төв аймгийн ЗДТГ-ын 2019 оны үйл ажиллагааны үр дүн, хууль тогтоомж тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүрэг, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт, байгууллагын ил тод байдлын үнэлгээ, шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ, шударга байдлын түвшний үнэлгээ, хэрэглэгчийн үнэлгээний тайлан зэрэгт Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан мэдээг ЗГХЭГ-т хүргүүлэв. Үнэлгээний дүнг хүснэгтээр харуулав.

Үзүүлэлт		Хувь 100.0	Жин 0.6	Оноо 5.00
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	95.72	0.574	4.78
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	95.38	0.572	4.77
	3. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	93.93	0.564	4.69
	4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	94.28	0.566	4.71
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	90.07	0.540	4.50
Дундаж үнэлгээ		93.88	0.563	4.69
Үзүүлэлт				
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	95.46	0.573	4.77
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	100.0	0.600	5.00
Дундаж үнэлгээ		97.73	0.586	4.89
Үзүүлэлт				
Байгууллагын	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	95.71	0.574	4.79

нээлттэй байдлын үнэлгээ	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	93.80	0.563	4.69
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	77.30	0.464	3.87
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	66.92	0.402	3.346
Дундаж үнэлгээ		83.43	0.501	4.17
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ:		91.68	0.550	4.58

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН (Харьцуулалт)**

Үзүүлэлт		2017 он			2018 он			2019 он		
		Хувь 100.0	Жин 0.6	Оноо 5.00	Хувь 100.0	Жин 0.6	Оноо 5.00	Хувь 100.0	Жин 0.6	Оноо 5.00
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	90.12	0.541	4.506	93.97	0.564	4.699	96.20	0.577	4.81
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	70.37	0.422	3.518	85.88	0.515	4.294	95.38	0.572	4.77
	3.Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт /Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт /	90.45	0.543	4.523	93.28	0.560	4.664	93.93	0.564	4.69
	4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	90.03	0.540	4.501	86.49	0.519	4.325	94.28	0.566	4.71
	5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	89.12	0.535	4.456	93.33	0.560	4.666	89.30	0.536	4.47
Дундаж үнэлгээ		85.87	0.602	0.516	90.59	0.544	4.530	93.82	0.563	4.69
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	91.62	0.183	4.581	94.92	0.190	4.746	96.14	0.577	4.81
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	92.50	0.185	4.625	95.00	0.190	4.750	100.0	0.600	5.00
Дундаж үнэлгээ		92.06	0.184	4.603	94.96	0.190	4.748	98.07	0.588	4.90
Байгууллагын нээлттэй байдлын	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	96.66	0.193	4.833	91.67	0.183	4.584	94.21	0.565	4.71
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	98.40	0.197	4.920	98.50	0.197	4.925	93.80	0.563	4.69

үнэлгээ	3. Шударга байдлын түвшний үнэлгээ							77.30	0.464	3.87
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	64.00	0.128	3.200	86.47	0.173	4.324	66.92	0.402	3.346
Дундаж үнэлгээ		86.35	0.173	4.318	92.21	0.184	4.611	83.06	0.498	4.15
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ:		87.30	0.873	4.365	92.59	0.926	4.630	91.65	0.550	4.58

“Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 олон улсын стандартын хүрээнд аймгийн ЗДТГ-ын хэлтэс, нэгжүүдэд дотоод аудит хийж, илэрсэн үл тохирлыг залруулах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллав.

Батлагдсан удирдамжийн дагуу Архуст, Баян, Баянцагаан, Бүрэн, Өндөрширээт, Сэргэлэн сумдад зөвлөн туслах чиглэлээр ажиллав.

Санхүүгийн хяналтын чиглэлээр: 2020 оны 03 дугаар сарын 27-ны байдлаар Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад сумдын Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 он, Баянчандмань сумын политехникийн коллеж, Эрдэнэ сумын МСҮТ, Зуунмод сумын МСҮТ, Сүмбэр, Жаргалант сумын төсөвт байгууллагууд, аймгийн Музей, БСУГ, Монгол туургатан театрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нийт 169914,1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 31810.3 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 138103.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоов. Улсын байцаагчийн актаас 1040.8 мянган төгрөг төлөгдсөн байна.

Өмнөх оны актын үлдэгдэл 109224.0 мянган төгрөгөөс 7022.0 мянган төгрөг төлөгдөж 102202.0 мянган төгрөгийн акт барагдаагүй байна.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн энхийг сахиулах ажиллагаанд оролцсон эмэгтэй албан хаагчдыг баярын нэвтрүүлэгт оруулах бэлтгэл ажлыг зохион байгуулж Төв аймгийн “Төв телевиз”-ээр Ахмад Г.Өнөржаргал, дэслэгч Ш.Гэрэл, ахлах ахлагч Т.Оюундарь, Н.Жавзандулам, Б.Ундрмаа, ахлагч Н.Цогзолмаа нарыг оролцууллаа.

Төв аймгийн 27 сумын ЕБС-ийн сурагчдын дунд “Бид эх орныхоо төлөө юу хийж чадах вэ” сэдвээр ЭССЕ бичлэгийн уралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулахад 26 сурагчид оролцож 7 нь шалгарлаа.

“Төв” телевизээр Монгол цэргийн өдөр болон Зэвсэгт хүчний 99 жилийн ойн баярын өдөрт зориулж Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлтэй хамтран “Салааны захирагчийн ажлын нэг өдөр” нэвтрүүлгийг хийж, Мотобуудлагын салааны захирагч дэслэгч З.Мягмарсүрэнг зочиноор оролцуулав.